



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/156

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны А/129 дүгээр тушаалаар Жаргалант сум Залуусын хорооллын дэд бүтцийн ажлын үнэлгээний хорооны дарга Б.Ганболд нь үнэлгээний хорооны даргаар ажиллахаас татгалзсан тул дээрхи ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга: Ш.Нохойжав

-Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Н.Эрдэнэцэцэг

-Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Д.Нямжаргал

- Төрийн бус байгууллагын төлөөлөл

О.Энхтунгалаг

- Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Ж.Батлхагва – Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ш.Нохойжав /-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэг үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Ж.Батлхагва /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

D/Tush-A/156-Da

02 00762